



МОНГОЛ УЛС  
ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2023 оны 04 сарын 21 өдөр

Дугаар А/195

Мөрөн сум

Үйл ажиллагааны жагсаалт төсөвт  
өртөг батлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, 60.1.5, 66 дугаар зүйлийн 66.1, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, 41 дүгээр зүйлийн 41.2.2 дэх хэсэг, Харилцаа холбооны тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.1 дэх заалт, Монгол Улсын Засгийн газрын 2022 оны 12 дугаар сарын 28-ны өдрийн 499 дүгээр тогтоол, аймгийн Засаг даргын Зөвлөлийн 2023 оны 4 дүгээр сарын 19-ний өдийн 7 дугаар хуралдааны шийдвэрийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Хөвсгөл аймагт Төрийн цахим үйлчилгээний хэлтэс шинээр байгуулагдаж аймгийн Засаг дарга, Цахим хөгжил харилцаа холбооны сайдтай байгуулсан хамтын ажиллагааны гэрээний 2.3.17, 2.3.18 дахь заалтын хэрэгжилтийг хангах хүрээнд “Хурдан” брэндийн үйлчилгээ үзүүлэх байрыг Brandbook загварын дагуу тохижуулах, засвар үйлчилгээ хийх, техник хэрэгсэл худалдан авах зардалд 19,926,000 (Арван есөн сая есөн зуун хорин зургаан мянга) төгрөгийг хавсралтад заасны дагуу зарцуулсугай.
2. Батлагдсан хөрөнгийн 12,340,000 (Арван хоёр сая гурван зуун дөчин мянга) төгрөгийг Засаг дарга дансны “Мөрийн хөтөлбөрт тусгагдсан зарим арга хэмжээг хэрэгжүүлэх” зардлаас, 7,586,000 (Долоон сая таван зуун наян зургаан мянга) төгрөгийг Засаг даргын нөөц хөрөнгөөс тус тус гаргаж зарцуулахыг аймгийн Засаг даргын Тамгын газар (Б.Мөнгөн-Эрдэнэ)-д зөвшөөрсүгэй.
3. Батлагдсан хөрөнгийг холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн зориулалтын дагуу зарцуулж, гүйцэтгэлийг тайлагнаж ажиллахыг Төрийн цахим үйлчилгээний хэлтэс (Д.Сумаадагва)-д үүрэг болгосугай.
4. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын орлогч (М.Хуягбаатар)-т даалгасугай.

ДАРГА



Ш.ИДЭРБАЯСГАЛАН

Захирамж-2023

671 1010601



Аймгийн Засаг даргын 2023 оны 04 дүгээр  
сарын 21-ний өдрийн 11/185 дугаар  
захирамжийн хавсралт

**Засвар тохижилт**

№	Тоног төхөөрөмжийн нэр	Тоо	Нэгж үнэ		Нийт үнэ
1	Арга зүйн өрөөний тохижилт	1	2,500,000		2,500,000
2	Шилэн хана хаалга	1м2	310,000	21м2	6,510,000
3	Таславч хана	1	850,000	4	3,400,000
3	Хана	1м2	14,000	42м2	588,000
4	Тааз	1м2	28,000	36м2	1,008,000
5	Шал	1м2	30,000	36м2	1,080,000
6	Хүлээлгийн сандал	3	350,000		1,050,000
7	Ажлын хөлс	1	900,000		900,000

**17,036,000**

**Хэвлэлийн үйлчилгээ**

№	Үйлчилгээний нэр	Тоо	Нэгж үнэ		Нийт үнэ
1	Гадна гэрэлт самбар, гадна хаягжилт	1	800,000		800,000
2	Туг лого Брэндбүүк ,хэвлмэл материаллын зардал	2	400,000		800,000
3	Брэндбүүк ,хэвлмэл Хана хийх зардал	1	1,150,000		1,150,000
4	Босоо стенд	2	70,000		140,000

**2,890,000**

**Нийт**

**19,926,000**

\_\_\_оОо\_\_\_